



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 380

Улаанбаатар хот

Г “Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон Т тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:


1. “Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх журам”-ын шинэчилсэн найруулгыг нэгдүгээр хавсралтаар, “Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийн ангилал, чиглэл, индекс, бүртгэлийн дугаар”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийн бүртгэлийн маягт”-ыг гуравдугаар хавсралтаар, тусгай зөвшөөрлийн, нэгжийн зөвшөөрлийн, бүртгэлийн, эрхийн гэрчилгээ, түүний хавсралт, үнэмлэхний загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх журам”, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 406 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зарим зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам”-ын 3 дугаар, 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 3, 4 дүгээр, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 7, 8 дугаар, 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 3, 4 дүгээр, 2010 оны 207 дугаар тогтоолоор баталсан “Бүртгэлийн гэрчилгээний загвар батлах тухай”-ын 1 дүгээр, 2010 оны 149 дүгээр тогтоолоор баталсан “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 4, 5 дугаар хавсралтаар баталсан гэрчилгээ, үнэмлэхний загварыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Гэрчилгээ түүний хавсралт, үнэмлэхийг батлагдсан загварын дагуу хэвлүүлж, зохицуулалтын байгууллагад олгоход бэлэн болгохыг Захиргаа удирдлагын газар /Б.Батзориг/-т даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 17. дугаар сарын 19.-ний өдрийн
389 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС ОЛГОСОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛ, ЭРХИЙН НЭГДСЭН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Санхүүгийн зохицуулах хороо/цаашид “Хороо”гэх/-ноос тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх /цаашид хамтад нь “нэгдсэн бүртгэл” гэх/, түүнд орсон өөрчлөлтийн тэмдэглэл хөтлөхөд энэхүү журмыг баримтална.
- 1.2. Нэгдсэн бүртгэлийг Хороо болон эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох шийдвэр, албан бичгийг үндэслэл болгон тухай бүр хөтөлнө.

ХОЁР. НЭГДСЭН БҮРТГЭЛИЙН АНГИЛАЛ, ДУГААР ТОГТООХ

2.1. Нэгдсэн бүртгэлийг дараах 4 ангиллаар бүртгэнэ. Үүнд:

2.1.1. тусгай зөвшөөрөл:

2.1.1.1. Үнэт цаасны зохицуулалттай үйл ажиллагаа;

/Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.1-24.1.14, 24.1.18/

2.1.1.2. Даатгал болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа;

/Даатгалын тухай хуулийн 13.1.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.2/

2.1.1.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа;

/Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4.1.1, 7.1./

2.1.1.4. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа;

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 10.1/

2.1.1.5. Хөдөө аж ахуйн зуучлагч брокерийн үйл ажиллагаа;

/Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бүтээгдэхүүний тухай хуулийн 4.9, 11.2.5/

2.1.1.6. Хорооноос олгогдох бусад тусгай зөвшөөрөл хамаарна.

2.1.2. зөвшөөрөл:

2.1.2.1. Салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан үйл ажиллагаа

явуулах; /Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26.2.12, Даатгалын тухай хуулийн 54.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.4/

2.1.2.2. Дүрмийн сангийн бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт оруулах;

2.1.2.3. Оноосон нэр өөрчлөх;

2.1.2.4. Эрх бүхий албан тушаалтныг томилох;

2.1.2.5. Хорооноос олгогдох бусад зөвшөөрөл хамаарна.

2.1.3. бүртгэл:

2.1.3.1. Үнэт цаасны зохицуулалтай үйл ажиллагаа;

/Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.15-24.1.17/

2.1.3.2. Нийтэд санал болгон гаргасан үнэт цаас;

/Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.15-24.1.17/

2.1.3.3. Хаяг байршил өөрчлөх;

2.1.3.4. Хорооноос олгогдох бусад бүртгэл хамаарна.

2.1.4.эрх:

2.1.4.1. Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах;

2.1.4.2. Зэрэглэл тогтоох этгээдэд олгох;

2.1.4.3. Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуульч, үнэлгээчин, аудиторын;

2.1.4.2. Даатгалын байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын компанийн;

2.1.4.3. Даатгалын актуарчийн;

2.1.4.4. Даатгалын байгууллагад аудит хийх аудиторын;

2.1.2.4. Хорооноос олгогдох бусад эрх хамаарна.

2.2. Нэгдсэн бүртгэлийг Хорооны хяналт, зохицуулалтад хамаарах зах зээл, салбар тус бүрээр энэхүү журмын Хавсралт 2-т заасны дагуу ангилж, чиглэл бүрээр индекс, бүртгэлийн дугаар олгоно.

2.3. Энэ журмын хавсралтад Хорооны Ажлын албаны даргын шийдвэрээр өөрчлөлт оруулна.

2.4. Энэ журмын 2.1-д дурдсан ангилал нь индекс, бүртгэлийн дугаартай байх бөгөөд бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, нэгжийн гэрчилгээ, бүртгэл, эрхийн гэрчилгээ /цаашид хамтад нь “гэрчилгээ” гэх/, үнэмлэхний дугаарыг давхардуулан олгохгүй.

2.5. Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийг Хавсралт 2-т заасны дагуу бүртгэнэ.

2.6. Индекс, бүртгэлийн дугаар нь тэмдэгтээс бүрдэх ба эхний 1-ээс 2 тэмдэгт нь бүртгэлийн ангилалыг, дараагийн 3 тэмдэгт нь үйл ажиллагааны чиглэлийг, сүүлийн цифрүүд нь Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийг бүртгэлд бүртгэсэн дэс дугаар/дараалал байна.

2.7. Эхний 5 тэмдэгтийн дараа ташуу “/” зураас байх ба энэ нь үйл ажиллагааны ангилал, чиглэлийг бүртгэлийн дэс дугаараас ялгаж өгнө.

2.8. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар нь 9 тэмдэгтээс бүрдэх бөгөөд тэмдэгт бүр дараах утгыг илэрхийлнэ. Үүнд:

2.8.1. 1-2 дахь 2 тэмдэгт: ангилал;

2.8.2. 3-5 дахь 3 тэмдэгт: чиглэл;

2.8.3. 6 дахь тэмдэгт: ташуу “/” зураас;

2.8.4. 7-9 дэх 3 тэмдэгт: тухайн чиглэлийн тусгай зөвшөөрөл олгосон, бүртгэсэн дараалал.

2.9. Нэгжийн зөвшөөрлийн гэрчилгээний дугаар нь 12 тэмдэгтээс бүрдэх бөгөөд тэмдэгт бүр дараах утгыг илэрхийлнэ. Үүнд:

2.9.1. 1 дэх тэмдэгт: ангилал;

2.9.2. 2-4дэх 3 тэмдэгт: чиглэл;

2.9.3.5 дахь тэмдэгт: ташуу “/” зураас;

2.9.4. 6-8 дахь 3 тэмдэгт: тухайн чиглэлийн тусгай зөвшөөрөл бүртгэсэн дараалал;

2.9.5. 9 дэх тэмдэгт: ташуу “/” зураас;

2.9.6. 10-12 дахь 3 тэмдэгт: тухайн хуулийн этгээдийн салбар, холбогдох тэмдэгт нэгжийн дугаар.

2.10. Эрхийн гэрчилгээ, үнэмлэхний дугаар нь 8 тэмдэгтээс бүрдэх бөгөөд тэмдэгт бүр дараах утгыг илэрхийлнэ. Үүнд:

2.10.1.1 дэх тэмдэгт: ангилал;

2.10.2.2-4дэх 3 тэмдэгт: чиглэл;

2.10.3.5 дахь тэмдэгт: ташуу “/” зураас;

2.10.4.6-8 дахь 3 тэмдэгт: тухайн чиглэлэийн тусгай зөвшөөрөл бүртгэсэн дараалал.

2.11. Хороо энэ журмын Хавсралт 2 дахь тусгай зөвшөөрлийн ангилалд хамаарах хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газарт нэгжийн зөвшөөрлийн гэрчилгээ, бүртгэл, эрхийн ангилалд хамаарах хуулийн этгээдэд бүртгэл, эрхийн гэрчилгээ, эрх олгосониргэнд үнэмлэх олгоно.

2.12. Хороо энэ журмын Хавсралт 4-т заасан тусгай зөвшөөрлийн, нэгжийн зөвшөөрлийн, бүртгэлийн, эрхийн гэрчилгээг зохицуулалттай хуулийн этгээдэд, үнэмлэхийг эрх олгосон иргэнд олгоно.

2.13. Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэмэгдсэн тохиолдолд ангилал тус бүрээр бүртгэлийн дугаарыг давхардуулахгүйгээр үргэлжлүүлэн олгоно.

ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ НЭГДСЭН ДУГААР, АНГИЛЛЫН КОД

3.1. Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаас нь нэгдсэн дугаар, ангиллын кодтой байна.

3.2. Үнэт цаасыг бүртгэхдээ ISO 10962:2001 олон улсын стандарт, “Үнэт цаас болон холбогдох санхүүгийн хэрэгслүүд-Санхүүгийн хэрэгслийн ангилал (СХА код)”MNS ISO 10962:2003 үндэсний стандартыг баримтална.

3.3. Журмын 3.2-т заасан дугаарыг энэхүү журмын 4.1-т заасан Үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлийн “Маягт А2”-т бүртгэнэ.

3.4. Өргөдлийг хянан шийдвэрлүүлэх албан хаагч нь системд Үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэсэн шийдвэрийг хавсаргаж, холбогдох мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд оруулна.

ДӨРӨВ. НЭГДСЭН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ГЭРЧИЛГЭЭ, ҮНЭМЛЭХ ОЛГОХ

- 4.1. Энэ журмын 2.1-т заасан нэгдсэн бүртгэлд хамаарах хуулийн этгээдийн мэдээллийг “Маягт А1”, нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг “Маягт А2”, иргэний мэдээллийг “Маягт А3”-аар тус тус бүртгэнэ.
- 4.2. Энэ журмын 2.1-д заасан нэгдсэн бүртгэлд хамаарах мэдээллийг тухайн өргөдөл гаргагч этгээд Хорооны “Зөвшөөрлийн цахим систем” /цаашид “систем” гэх/-д оруулж, илгээснээр бүртгэлийн цахим мэдээллийн сан үүснэ.
- 4.3. Хороо өргөдлийг хүлээн авах хүртэлх хугацааны систем дэх болон цаасаар хүлээн авсан баримт бичгийн бүрэн гүйцэд эсэхэд Хорооны нэгдсэн бүртгэл хариуцсан албан хаагч хяналт тавьж ажиллана.
- 4.4. Өргөдлийг хянан шийдвэрлүүлэх албан хаагч нь Хороо өргөдлийг хүлээн авснаас хойшхи хугацааны өргөдөл гаргагч этгээдээс системээр болон цаасаар ирүүлсэн баримт бичиг, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд эсэхэд хяналт тавьж ажиллана.
- 4.5. Тухайн асуудлыг хянан, шийдвэрлүүлсэн албан хаагч энэхүү журмын 4.1-т заасан маягтад агуулах мэдээллийг үнэн зөв бөглөж, баталгаажуулан нэгдсэн бүртгэл хариуцсан албан хаагчид шийдвэрийн хамт цаасаар хүлээлгэн өгнө.
- 4.6. Нэгдсэн бүртгэл хариуцсан албан хаагч системд шийдвэрийг хавсаргаж, цаасаар хүлээн авсан маягтыг эцэслэн хянаж, Ажлын албаны даргаар баталгаажуулсны дараа гэрчилгээ, үнэмлэхийг хэвлэж, дугаарлан, Хорооны даргад танилцуулан, албажуулж, хянан шийдвэрлүүлсэн албан хаагчид хүлээлгэн өгнө.
- 4.7. Гарсан өөрчлөлт тухай бүр нэгдсэн бүртгэл хариуцсан албан хаагч гэрчилгээний хавсралтад тэмдэглэж, “Бүртгэв” тэмдэг даран, системд бүртгэж, хүлээлгэн өгнө.
- 4.8. Нэгдсэн бүртгэл хариуцсан албан хаагч албажуулсан гэрчилгээ, үнэмлэхийг хүлээлгэн өгсний дараа 4.1-т заасан маягтын мэдээллийг нэгдсэн бүртгэлийн ангилал бүрээр цаасан болон цахим архив үүсгэнэ.
- 4.9. Иргэн, хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийн гэрчилгээ, үнэмлэхийг үрэгдүүлсэн, гэмтээсэн болон оноосон нэрээ өөрчилсөн тохиолдолд холбогдох хүсэлтийг үндэслэн дахин олгох, энэ талаар системд бүртгэх ажлыг Хорооны нэгдсэн бүртгэл хариуцсан албан хаагч хариуцна.
- 4.10. Гэрчилгээ, үнэмлэхийг дахин олгоходоо үрэгдүүлсэн бол нийтэд мэдээлснийг нотлох баримтыг үндэслэж, албажуулан олгоно.
- 4.11. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийн гэрчилгээ, үнэмлэхийг үрэгдүүлсэн тохиолдолд дахин олгоход энэхүү журмын 2.8, 2.9, 2.10-д заасан бүртгэлийн дугаарт өөрчлөлт орно
- 4.12. Тусгай зөвшөөрөл, нэгжийн зөвшөөрөл, бүртгэл, эрхийн гэрчилгээ үнэмлэх гэмтээсэн болон оноосон нэрээ өөрчилсөн тохиолдолд дахин олгоход энэхүү журмын 2.8, 2.9, 2.10-д заасан дугааруудад өөрчлөлт орохгүй бөгөөд хураагдсан тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн гэрчилгээ, бүртгэл, эрхийн гэрчилгээ, үнэмлэхэд нэгдсэн бүртгэл хариуцсан албан хаагч “Хүчингүй” тэмдэг дарж, хянан шийдвэрлүүлсэн албан хаагчид хүлээлгэн өгнө.

ТАВ. БУСАД

- 5.1. Нэгдсэн бүртгэл хариуцсан албан хаагч бүртгэлтэй холбоотой шийдвэрийг Хорооны бусад албан хаагчаас шаардах эрхтэй.

5.2. Хорооноос баталсан мэдээллийн нууцлалтай холбоотой журам, зааврыг чанд мөрдөж ажиллана.

5.3. Нэгдсэн бүртгэл хариуцсан албан хаагчын хууль, журмаар хүлээсэн эрх, үүргийн биелэлтэд нэгдсэн бүртгэл хариуцсан нэгжийн удирдах албан тушаалтан хяналт тавьж ажиллана.

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн
38 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



**Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийн ангилал, чиглэл, төрөл,
индекс, бүртгэлийн дугаар**

Ангилал	Чиглэл	Үйл ажиллагааны төрөл	Индекс	Бүртгэлийн дэс дугаар
Тусгай зөвшөөрөл	Үнэт цаасны зах зээл/ салбар		T3 300/...	Ерөнхий бүлгийн дугаар...
		Зохицуулалттай этгээд	T3 301/...	
		Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх;	*	
		Үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх;	*	
		Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх;	*	
		Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх;	*	
		Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа эрхлэх;	T3 302/...	
		Үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх;	T3 303/...	
		Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх;	T3 304/...	
		Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа эрхлэх;	T3 305/...	
		Кастодианы үйл ажиллагаа эрхлэх;	T3 306/...	
		Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх;	T3 307/...	
		Үнэт цаасны итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх;	T3 308/...	
		Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх;	T3 309/...	
		Үнэт цаасны итгэмжлэн удирдах	T3 310/...	
		Дилерүүдийн арилжааны төвийн үйл ажиллагаа эрхлэх;	T3 311/...	
		Хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх;	T3 312/...	
		Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх;	T3 313/...	
		Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх;	T3 314/...	
		Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх;	T3 315/...	
		Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх;	T3 316/...	
Хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа эрхлэх;	T3 317/...			
<i>Журмын 2.13-т заасны дагуу</i>	T3 318/...			
Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн зах		T3 500/...		

зээл/салбар			
	Хөдөө аж ахуйн зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх;	ТЗ 501/...	
	Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн үйл ажиллагаа эрхлэх;	ТЗ 502/...	
	<i>Журмын 2.13-т заасны дагуу</i>	ТЗ 503/...	
Даатгалын зах зээл/салбар		ТЗ 200/...	
	Даатгагч		
	Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх;	ТЗ 201/...	
	Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх;	ТЗ 202/...	
	Давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх;	ТЗ 203/...	
	<i>Журмын 2.13-т заасны дагуу</i>	ТЗ 204/...	
	Мэргэжлийн оролцогч		
	Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх;	ТЗ 210/...	
	Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх;	ТЗ 211/...	
	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх;/ асуух	ТЗ 212/...	
	<i>Журмын 2.13-т заасны дагуу</i>	ТЗ 213/...	
Банк бус санхүүгийн байгууллагын зах зээл/салбар		ТЗ 100/...	
	Банк бус санхүүгийн үйл ажиллагаа	ТЗ 101/...	
	Зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн төрөл:	*	
	Факторингийн үйл ажиллагаа эрхлэх;	*	
	Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх;	*	
	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагаа эрхлэх;	*	
	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх;	*	
	Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх;	*	
	Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх;	*	
	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа эрхлэх;	*	
	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;	*	
	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	*	
	<i>Журмын 2.13-т заасны дагуу</i>	ТЗ 102/...	
Хадгаламж, зээлийн хоршооны зах зээл/салбар		ТЗ 400/...	
	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	ТЗ 401/...	
	<i>Журмын 2.13-т заасны дагуу</i>	ТЗ 402/...	

Ангилал	Чиглэл	Үйл ажиллагааны төрөл	Индекс	Бүртгэлийн дэс дугаар
Зөвшөөрөл	Үнэт цаасны зах зээл/салбар		3 300/...	Ерөнхий бүлгийн дугаар...
		Зохицуулалттай этгээд	3 301/...	
		Зохицуулалттай этгээд нь өөрийн салбар нээх;	3 .../.../С...	
		Зохицуулалттай этгээд нь өөрийн төлөөлөгчийн газар нээх;	3 .../.../Т...	
		Зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирлыг томилох;	*	
		Оноосон нэр өөрчлөх;	*	
		Дүрмийн сангийн бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт оруулах;	*	
		Гадаад улсын үнэт цаасны зах зээл дээр үнэт цаас худалдан авах, худалдахад зуучлах;	*	
	Харилцагчийн нэгдсэн /номинал/ данс эзэмших;	*		
	Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн зах зээл/салбар		3 500/...	
		Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэцэд өөрчлөлт оруулах;	*	
		Оноосон нэрийг өөрчлөх;	*	
		Нэгж байгуулах;	3 .../.../С...	
	Даатагалын зах зээл/салбар		3 200/...	
		Даатгагч		
		Компанид салбар нээн ажиллуулах;	3 .../.../С...	
		Компанид төлөөлөгчийн газар нээн ажиллуулах;	3 .../.../Т...	
		Оноосон нэрийг өөрчлөх;	*	
		Даатгагчид сайн дурын даатгалын хэлбэрийг нэмэх;	*	
		Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын;	*	
		Гадаадын мэргэжлийн оролцогч Монгол улсад салбар, төлөөлөгчийн газар нээх;	ГМ .../.../...	
Даатгагчийн салбар, төлөөлөгчийн газраа гадаад улсын нутаг дэвсгэрт нээх;		ДМ.../.../...		
Даатгагч даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлэх болон нэгтгэх;				
Дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;		*		
Гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулах;		3201/.../Г...		
Эрх бүхий албан хаагч томилохыг зөвшөөрөх		*		
Мэргэжлийн оролцогч				
Компанид салбар нээн ажиллуулах;		3 .../.../С...		
Компанид төлөөлөгчийн газар нээн	3 .../.../Т...			

	ажиллуулах;		
	Оноосон нэрийг өөрчлөх;	*	
	Дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;	*	
	Эрх бүхий албан хаагч томилохыг зөвшөөрөх	*	
Банк бус санхүүгийн байгууллагын зах зээл/салбар		3 100/.../...	
	Хоёрдогч өглөгийн;	*	
	Нэгж салбар нээн ажиллуулах	3 101/.../С...	
	Нэгж төлөөлөгчийн газар нээн ажиллуулах	3 101/.../Т...	
	Оноосон нэр өөрчлөх;	*	
	Дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;	*	
Хадгаламж, зээлийн хоршооны зах зээл/салбар		3 400/...	
	Санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх;	*	
	Төслийн санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэх;	*	
	Цахим төлбөр тооцооны төлөөлөгчөөр ажиллах үйлчилгээ үзүүлэх;	*	
	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа;	*	
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ;	*	
	Хуримтлалын сан үүсгэх, удирдах үйл ажиллагаа	*	
	Салбар нээн ажиллуулах	3 401/.../С...	
	Оноосон нэр өөрчлөх;	*	
	Өөрчлөн байгуулах;	*	

Ангилал	Чиглэл	Үйл ажиллагааны төрөл	Индекс	Бүртгэлийн дэс дугаар
Бүртгэл	Үнэт цаасны зах зээл/салбар		Б 300/.../...	Ерөнхий бүлгийн дугаар...
		Өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагаа явуулах;	Б 350/...	
		Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх;	Б 351/...	
		Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх;	Б 352/...	
		Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх;	Б 353/...	
		Хувьцаат компанийн хувьцаа;	*	
		Компанийн өрийн хэрэгсэл;	*	
		Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бүртгэл;	*	
		Хадгаламжийн бичиг;	*	
		Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж эрх;	*	
		Монгол улсын хуулийн этгээд гадаад улсын зах зээлд гаргасан үнэт цаасны;	*	
		Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн;	*	
		Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх мэргэшсэн нягтлан бодогчийн;	Б 354/...	
		Нийтэд болгон гаргах үнэт цаас болон хоёрдогч зах зээлийн арилжаа эхлүүлэх зөвшөөрөл;	*	
		<i>Журмын 2.13-т заасны дагуу</i>	Б 355/...	
	Даатагалын зах зээл/салбар		Б 200/...	
		Фронтингийн үйлчилгээ үзүүлэх	*	
		Бүтээгдэхүүн	*	
	Банк бус санхүүгийн байгууллагын зах зээл/салбар		Б 100/...	
		Гүйцэтгэх удирдлага өөрчлөгдөх	*	
		Хаяг байршил өөрчлөгдөх	*	
	Хадгаламж, зээлийн хоршооны зах зээл		Б 400/...	
		Сонгууульт гишүүд, гүйцэтгэх удирдлага өөрчлөгдөх	*	
		Хаяг байршил өөрчлөгдөх	*	

Ангилал	Чиглэл	Үйл ажиллагааны төрөл	Индекс	Бүртгэлийн дэс дугаар	
Эрх	Үнэт цаасны зах зээл/салбар	Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох;	Э 330/...		
		Зэрэглэл тогтоох этгээдэд олгох;	Э 331/...		
		Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуульч	Э 332/...		
		Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийнүнэлгээний үйлчилгээ үзүүлэх үнэлгээчин	Э 333/...		
		Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх аудитор	Э 334/...		
		<i>Журмын 2.13-т заасны дагуу</i>	Э 335/...		
	Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн зах зээл/салбар			Э 500/..	
		Хөдөө аж ауйн биржид ажиллах брокерийн зөвшөөрөл олгох;	Э 520/...		
		<i>Журмын 2.13-т заасны дагуу</i>	Э 521/...		
	Даатгалын зах зээл/салбар			Э 200/...	
		Даатгалын байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын компанийн эрх;	Э 220/...		
		Даатгалын актуарчийн;	Э 221/...		
		Даатгалын байгууллагад аудит хийх аудиторт эрх олгох;	Э 222/...		
		<i>Журмын 2.13-т заасны дагуу</i>	Э 223/...		

Үсгэн тэмдэглэгээний тайлбар:

- ТЗ - Тусгай зөвшөөрөл
- З - Зөвшөөрөл
- Б – Бүртгэл
- Э – Эрх
- С- Салбар
- Т- Төлөөлөгчийн газар
- Г - Гэрээ
- ГМ- Гадаадын мэргэжлийн оролцогч/Даатгал/
- ДМ-Дотоодын мэргэжлийн оролцогч/Даатгал/
- *-Гэрчилгээний хавсралт дахь бичилт

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн
386 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт
Маягт А1



**Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл,
бүртгэл, эрхийн маягт**

Бүртгэлийн дугаар

№	Бүртгэлийн асуулга		Үзүүлэлт
1	Тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд	Хуулийн этгээдийн нэр	
		Хуулийн этгээдийн бүртгэлийн	Дугаар Регистрийн дугаар
		Өмчийн хэлбэр	
		Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /төг/	
		Хувь нийлүүлэгчийн тоо, овог нэр, регистр, эзэмших дүн, эзэмших хувь	
		Хөрөнгө оруулалтын хэлбэр	
		Эрхэлж буй үйл ажиллагаа	
		Хаяг, байршил	
		Гүйцэтгэх захирлын овог, нэр, регистрийн дугаар, утас, имэйл	
		ТУЗ-ийн дарга, гишүүдийн овог, нэр, регистрийн дугаар, утас, имэйл	
		Тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга, гишүүдийн овог, нэр, регистрийн дугаар, утас,	
		Дотоод хяналтын ажилтны овог, нэр, регистр, утас, имэйл	
		Хяналтын зөвлөлийн гишүүдийн овог, нэр, регистр, утас, имэйл	
		Ерөнхий нягтлан бодогчийн овог, нэр, регистрийн дугаар, утас, имэйл	
2	Хорооноос олгосон зөвшөөрөл, зөвшөөрөл бүртгэл, эрхийн	Эрхлэх үйл ажиллагааны	Төрөл Ангилал
		Олгосон шийдвэрийн	Огноо, дугаар Хүчинтэй байх хугацаа
		Индекс/ бүртгэлийн дугаар/	
		Бүртгэсэн огноо	
		Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, түүний хавсралтын хаясан, гэсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн, сэргээсэн тухай тэмдэглэл	

Баталсан: Албаны дарга / /
 Хянаж, зөвшөөрсөн: ЗУГ-ын дарга: / /
 Хянасан: Хариуцсан газрын дарга: / /
 Бүртгэсэн: Хариуцсан газрын хянан шалгагч: / /
 Хянасан: Бүртгэл хариуцсан хянан шалгагч: / /
 /Тэмдэг/

Нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл

Бүртгэлийн дугаар

№	Бүртгэлийн асуулга		Үзүүлэлт	
1	Үнэт цаас гаргагч	Байгууллагын нэр		
		Компанийн	Регистрийн дугаар	
			Улсын бүртгэлийн дугаар	
		Өмчийн хэлбэр		
		Эрхэлж буй үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл		
2	Тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа	Зөвшөөрлийн нэр		
		Олгосон шийдвэрийн	Дугаар	
			Огноо	
		Бүртгэлийн дугаар		
		Бүртгэсэн огноо		
3	Гаргасан үнэт цаасны	Төрөл		
		Нэр		
		Тоо, ширхэг		
		Нэг бүрийн нэрлэсэн үнэ		
		Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ		
		Андеррайтерийн мэдээлэл		

Баталсан: Албаны дарга / /
 Хянаж, зөвшөөрсөн: ЗУГ-ын дарга: / /
 Хянасан: Хариуцсан газрын дарга: / /
 Бүртгэсэн: Хариуцсан газрын хянан шалгагч: / /
 Хянасан: Бүртгэл хариуцсан хянан шалгагч: / /
 /Тэмдэг/

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны /2 дугаар сарын 14-ний өдрийн
310 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар . . .

. . . он . . . сар . . . өдөр

Монгол улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны ___оны ___сарын ___өдрийн ___дугаар тогтоолоор _____ -д

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

“Тамга”

Энэхүү гэрчилгээ нь
хавсралтын хамт
хүчинтэй



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**НЭГЖИЙН ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар . . .

. . . он . . . сар . . . өдөр

Монгол улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны ____ оны ____ сарын ____ өдрийн ____ дугаар тушаалаар _____ регитрийн дугаар бүхий _____-д _____ хот/аймаг-ийн _____ дүүрэг/сум-нд _____ байгуулахыг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

“Тамга”

Энэхүү гэрчилгээ нь
хавсралтын хамт
хүчинтэй

(Энэхүү хавсралт нь нэгжийн зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

**_____ ТООТ
НЭГЖИЙН ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ
ХАВСРАЛТ**

“Тэмдэг”

НЭГ. Хуулийн этгээдийн салбар, нэгжийн хаяг, түүний өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Хаяг	Утас	Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг

ХОЁР. Нэгжийн зөвшөөрлийн тэмдэглэл:

Д/д	Өөрчлөлтийн тэмдэглэл	Өөрчлөлтийг бүртгэсэн огноо, тэмдэг



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**БҮРТГЭЛИЙН
ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар . . .

. . . он . . . сар . . . өдөр

Монгол улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны ___оны ___сарын ___өдрийн ___дугаар тогтоолоор _____ -д

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

“Тамга”

Энэхүү гэрчилгээ нь
хавсралтын хамт
хүчинтэй

(Энэхүү хавсралт нь бүртгэлийн гэрчилгээний хамт хүчинтэй)



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

**ТООТ
БҮРТГЭЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ
ХАВСРАЛТ**

“Тэмдэг”

НЭГ. Хуулийн этгээдийн хаяг, түүний өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Хаяг	Утас	Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг

ХОЁР. Өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Өөрчлөлтийн тэмдэглэл	Өөрчлөлтийг бүртгэсэн огноо, тэмдэг



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**ЭРХИЙН
ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар . . .

. . . он . . . сар . . . өдөр

Монгол улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, бусадхолбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны ____оны ____сарын ____өдрийн ____дугаар тогтоолоор _____ -д

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

“Тамга”

Энэхүү гэрчилгээ нь
хавсралтын хамт
хучингэй

(Энэхүү хавсралт нь эрхийн гэрчилгээний хамт хүчинтэй)



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

**_____ ТООТ
ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
ХАВСРАЛТ**

“Тэмдэг”

НЭГ. Хуулийн этгээдийн хаяг, түүний өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Хаяг	Утас	Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг

ХОЁР. Өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Өөрчлөлтийн тэмдэглэл	Өөрчлөлтийг бүртгэсэн огноо, тэмдэг

ҮНЭМЛЭХ



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Дугаар ...

3*4
хэмжээтэй
Зураг

_____ овогтой

_____ -д

ҮНЭМЛЭХ



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Дугаар ...

3*4
хэмжээтэй
Зураг

_____ овогтой

_____ -д

Санхүүгийн зохицуулах хорооны даргын
___ оны ___ сарын ___ өдрийн ___ дугаар
тушаалаар _____ ХХК-д
даатгалын төлөөлөгчөөр тусгай
зөвшөөрөл олгов.

Санхүүгийн зохицуулах хорооны
дарга
Тамга

Санхүүгийн зохицуулах хорооны даргын
___ оны ___ сарын ___ өдрийн ___ дугаар
тушаалаар _____ ХХК-д

_____ үйл ажиллагаа эрхлэх эрх олгов

Санхүүгийн зохицуулах хорооны
дарга

Тамга